



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА ХҮРЭЛБААТАРЫН
БУЛГАНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025. 10. 30 № 35-1/123
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл
өргөн мэдүүлэх тухай

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.10.29 № ХТ/3020
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ³²³ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ


000255017063

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2025. 10. 21 № 01/2871

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцэж байгаа тул Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Н.УЧРАЛ

152504000576



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.10.28 № 01/9685

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Н.УЧРАЛ ТАНАА**

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын
Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн
тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт
заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002098



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 10. 28 № 1/1986

танай 2025. 10. 29-ны № 01/2892 -т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Н.УЧРАЛ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.




Б.ЭНХБАЯР

151603-89 А5 файл.2025

БАТЛАВ

БАТЛАВ

БАТЛАВ



2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

**“МОНГОЛ УЛСЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үндэслэл,
шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос хоёр сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсэгт “Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас нэг сарын өмнө батална.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Уг тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуультай уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1.а-д “урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг тодорхойлсон байх;” гэж, 6.7.1.б-д “хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;” гэж, 6.7.1.в-д тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргах.” гэж тус тус заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/13 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг баримтална.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 4 заалт, 4 хавсралттай байх бөгөөд нэгдүгээр заалтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үр дүнг хоёрдугаар хавсралтаар, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлах тухай, хоёрдугаар заалтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, холбогдох төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах тухай, гуравдугаар заалтад энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд үүрэг болгох тухай, дөрөвдүгээр заалтад тогтоолыг дагаж мөрдөх хугацааны тухай тус тус тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар хүний хөгжлийн түвшин, дундаж давхаргыг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн хөгжлийг шинэ шатанд гаргах, ногоон шилжилт, уур амьсгал ба сэргээгдэх эрчим хүчний шинэчлэлийн тогтвортой хөгжлийн суурийг бий болгох, эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлж, бизнесийн орчны шинэчлэлийг гүнзгийрүүлэх, дижитал шилжилт, төрийн шинэчлэлийн ил тод, хариуцлагатай байдал, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Тогтоолын төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль, тогтоомжийн төсөл байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсыг 2026-2030 онд
хөгжүүлэх таван жилийн үндсэн
чиглэл батлах тухай” Монгол Улсын
Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтад “Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 4.1.6-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах;” гэж, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, Засгийн газарт танилцуулна.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос хоёр сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулсан.

Уг төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1.а-д “урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг тодорхойлсон байх;” гэж, 6.7.1.б-д “хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;” гэж, 6.7.1.в-д “тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргах.” гэж тус тус заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/13 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг баримталсан болно.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл нь “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Засаглал, дижитал шилжилт”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд үндэсний 10, салбарын 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85, хөтөлбөрийн 200 үр дүнг тус тус тодорхойлсон.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

1. Боловсрол, эрүүл мэндийн салбарт хийх шинэчлэлийн хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.813 оноонд хүргэх;

2. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байран дахь осол гэмтэл, хөдөлмөрлөх эрхийн зөрчил, маргааныг бууруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлэх;

3. Иргэдийн оролцоо, соён гэгээрэл, хамтын хариуцлагыг нэмэгдүүлж, тэгш боломжийг ханган, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлэн, эв нэгдлийг бататган үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлтийг 55 хувьд хүргэх;

4. Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл тогтвортой байдлыг бэхжүүлж, хүний эрхийн баталгааг ханган, хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг 20 хувиар өсгөх;

5. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгалах;

6. Анхдагч экосистемийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулж, орчны чанар стандартыг сайжруулж байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтийг 59.0 оноонд хүргэх;

7. Авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулж, “Цахимаар түрүүнд” зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж зөв засаглалын үзүүлэлтээр эхний 90 орны нэг болох;

8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг 20 хувиар нэмэгдүүлэх;

9. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 50 орны нэг болгох;

10. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж Дэлхийн мэдлэгийн индексийг 52.4 оноонд хүргэх зэрэг юм.

Мөн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг үнэлж, ахиц дэвшлийг хянах, зорилтот үр дүнд чиглүүлэх зорилгоор үр дүн тус бүрийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшнийг тусган боловсруулсан.

Түүнчлэн хуульд заасны дагуу “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан бөгөөд түүнд хөгжлийн төслүүдийг эрэмбэлж, 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн, хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээнүүдийг тусгалаа.

“Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн 66.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 87 төслийг тусгасан ба тэдгээрийг нийт 55.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төслүүдийн 44.8 хувь буюу 39 төслийг улс, орон нутгийн төсвөөр, 28.7 хувь буюу 25 төслийг гадаадын зээл, тусламжаар, 16.1 хувь буюу 14 төслийг шууд хөрөнгө оруулалтаар, 3.4 хувь буюу 3 төслийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 2.3 хувь буюу 2 төслийг Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасаар, 3.4 хувь буюу 3 төслийг холимог эх үүсвэрээр, 1.1 хувь буюу 1 төслийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх юм. Тухайлбал, зарим томоохон төслүүдийг дурдвал,

Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, соёлын салбарт нийт 4.6 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд боловсролын салбарт улсын хэмжээнд 108 сургууль, 95 цэцэрлэгийг, эрүүл мэндийн салбарт Зүрх судасны үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын төв-II, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгыг, шинжлэх ухаан, соёлын салбарт Байгалийн шинжлэх ухааны музей, Үндэсний урлагийн их театр, Хүүхдийн номын ордон, Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг барьж байгуулна.

Боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарт нийт 18.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, мөн экспортын тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд Гашуунсухайт–Ганцмод, Ханги–Мандал, Шивээхүрэн–Сэхээ боомтын төмөр зам болон авто замын холболтын төслүүдийг хэрэгжүүлнэ.

Эрчим хүчний салбарт 15.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд Баянгийн 660 МВт-ын Дулааны Цахилгаан Станц, Тавантолгойн 450 МВт-ын Цахилгаан Станц, Эрдэнэбүрэнгийн Усан Цахилгаан Станц, Дулааны Ү Цахилгаан Станцыг шинээр байгуулна.

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд 13.6 их наяд төгрөгийн 36 төслийг хэрэгжүүлнэ. Үүнд Туулын хурдны зам, Шинэ тойрог зам, Нийтийн тээврийн дүүжин зам, төмөр зам доогуурх авто замын нүхэн гарц төсөл, баруун, зүүн, хангай, төвийн бүсийг холбосон авто замын төслүүд багтана. Тухайлбал, Чойр-Мандалговь-Арвайхээр, Бор-Өндөр-Хэрлэн, Улиастай-Алтай, Ховд-Улаангом, Баянхонгор-Шаргалжуут, Өлгий-Цэнгэл, Төв аймгийн холболтын зэрэг 10 гаруй чиглэлийг шинээр хатуу хучилттай авто замаар холбоно.

Төрийн институцийн чадавх, гамшгийн эрсдэлийн удирдлага болон үндэсний аюулгүй байдлын хамгаалалтыг бэхжүүлэхэд нийт 1.98 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тус тус төлөвлөсөн.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба олон нийтээр хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийн бодлогын 8 чиглэл, 4 түвшний үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулах зэрэг чиглэлээр нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд Шинжлэх ухааны академийн Бага болон Их чуулганаар хэлэлцүүлсэн нь шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулахад онцгой ач холбогдолтой болсон юм.

Олон нийтийн хэлэлцүүлэгт шүүх засаглалын байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, иргэний нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцож, өөрсдийн салбарын үр дүн, арга зам, шалгуур үзүүлэлтийн талаар нийтдээ 644 санал гаргаснаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/13 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг баримтлан холбогдох саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэл батлах тухай”**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 1 дүгээр, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-г 2 дугаар, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг 3 дугаар, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа улсын эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчдын болон тэдгээрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн түвшинд тулгамдаж байгаа асуудлыг тогтоож, уг асуудлуудыг шийдвэрлэснээр бий болох үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлт, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон болно. Мөн тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан бөгөөд үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан тусгасан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсрууллаа.

Үндсэн чиглэл нь Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн төсөв, байгууллагын стратеги төлөвлөгөө, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийн суурь болох юм. Үндсэн чиглэлд тодорхойлсон үр дүнг бодлого, төлөвлөлтийн эдгээр баримт бичигт тусган, үр дүнг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг уялдаа, хамааралтайгаар төлөвлөн хэрэгжүүлнэ.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь “Шинэ итгэл – Эрс шинэтгэл”-д зорин “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Засаглал, дижитал шилжилт”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд үндэсний 10, салбарын 35, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85, хөтөлбөрийн 200 үр дүнг тодорхойлсон болно.

Нэг. Хүний хөгжил

1.1. Боловсрол, эрүүл мэндийн салбарт хийх шинэчлэлийн хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.813 оноонд хүргэнэ.

1.2. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байран дахь осол гэмтэл, хөдөлмөрлөх эрхийн зөрчил, маргааныг бууруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.

Хоёр. Нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл

2.1. Иргэдийн оролцоо, соён гэгээрэл, хамтын хариуцлагыг нэмэгдүүлж, тэгш боломжийг ханган, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлэн, эв нэгдлийг бататган үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлтийг 55 хувьд хүргэнэ.

2.2. Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл тогтвортой байдлыг бэхжүүлж, хүний эрхийн баталгааг ханган, хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг 20 хувиар өсгөнө.

Гурав. Эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил

3.1. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгална.

Дөрөв. Байгаль орчин, ногоон эдийн засаг

4.1. Анхдагч экосистемийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжин, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүсэх бохирдол, хаягдлыг бууруулж, орчны чанар стандартыг сайжруулж байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтийг 59.0 оноонд хүргэнэ.

Тав. Засаглал, дижитал шилжилт

5.1. Авлигыг бууруулж, иргэдийн шүүхэд итгэх итгэл, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж, батлан хамгаалах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулж, “Цахимаар түрүүнд” зарчмыг хэрэгжүүлж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж зөв засаглалын үзүүлэлтээр эхний 90 орны нэг болно.

Зургаа. Бүсийн хөгжил

6.1. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг 20 хувиар нэмэгдүүлнэ.

Долоо. Үндэсний өрсөлдөх чадвар

7.1. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 50 орны нэг болно.

Найм. Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун

8.1. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээж Дэлхийн мэдлэгийн индексийг 52.4 оноонд хүргэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ҮР ДҮН

№	Бодлогын үндэслэл	Салбар/ТЕЗ/Хөтөлбөрийн нэр	Үр дүн	Арга зам	Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч
ХҮНИЙ ХӨГЖИЛ						
1	Үндэсний үр дүн (Бодлогын зорилго) 1: Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.					
1.1	АХ-2.1	Боловсрол	Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	Хувь хүний хөгжлийг дэмжих	Боловсролын яам	
1.1.1	АХ-2.1	Боловсролын яам	5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг сайжруулна.	Эцэг, эхийн оролцоог дэмжих	Боловсролын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
1.1.1.1	АХ-2.1.34	71801 Сургуулийн өмнөх боловсрол	Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна.	Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах	Боловсролын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
1.1.1.2	АХ-2.1.12	71801 Сургуулийн өмнөх боловсрол	Стандартын шаардлага хангасан орчин бүхий цэцэрлэгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Боловсролын яам	
1.1.2	АХ-2.1	Боловсролын яам	Иргэдийн суурь ур чадварын түвшнийг ахиулж, ялгаатай байдлыг бууруулна.	Бүх түвшний сургалтын хөтөлбөрийг шинэчилж, хэрэгжүүлэх	Боловсролын яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
1.1.2.1	АХ-2.1.12	71802 Ерөнхий боловсрол	Стандартын шаардлага хангасан орчин бүхий ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Боловсролын яам	
1.1.2.2	АХ-2.1.34	71802 Ерөнхий боловсрол	Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна.	Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах	Боловсролын яам	
1.1.3	АХ-2.1	Боловсролын яам	Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын зөрүүг сургалтын хөтөлбөртэй уялдуулах	Боловсролын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
1.1.3.1	АХ-2.1.28	71804 Мэргэжлийн боловсрол	Хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг нэмэгдүүлнэ.	Ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх	Боловсролын яам	
1.1.3.2	АХ-2.1.28	71803 Дээд боловсрол	Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр төгсөгчийг нэмэгдүүлнэ.	Сургалтын хөтөлбөрийг ажлын байрны ур чадвартай уялдуулах	Боловсролын яам	

1.1.3.3	АХ-2.1.44	71806 Насан туршийн суралцахуй	Албан ба албан бус боловсрол эзэмшсэн, сургалтад оролцсон иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.	Цахим болон зайны сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх	Боловсролын яам	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
1.2	АХ-2.2	Эрүүл мэнд	Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.	Хүн амын нийгэм, сэтгэлзүйн эрүүл мэндийн боловсрол, хандлагыг дээшлүүлэх	Эрүүл мэндийн яам	
1.2.1	АХ-2.2	Эрүүл мэндийн яам	Эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэдийг нэмэгдүүлнэ.	Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Эрүүл мэндийн яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
1.2.1.1	АХ-2.2.22	71601 Нийгмийн эрүүл мэнд	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх	Эрүүл мэндийн яам	
1.2.1.2	АХ-2.2.24	71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Эмийн чанарыг сайжруулна.	Эмийн хяналтыг сайжруулах	Эрүүл мэндийн яам	
1.2.1.3	АХ-2.2.23	71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ.	Үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх	Эрүүл мэндийн яам	Эдийн засаг, хөгжлийн яам
1.2.1.4	АХ-2.2.19	71605 Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн яам	Сангийн яам
1.2.1.5	АХ-2.2.25	71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний төрөл, чанарыг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн яам	
1.2.1.6	АХ-2.2.14	71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Эмнэлгийн бус нас баралтыг бууруулна.	Яаралтай, түргэн тусламжийн сүлжээг шинэчлэх	Эрүүл мэндийн яам	
1.2.2	АХ-3.5	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Эрүүл, зөв амьдралын хэв маягийг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Эрүүл мэндийн яам Боловсролын яам
1.2.2.1	АХ-3.5.1	71701 Биеийн тамир, спорт	Идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэх дадалтай хүн амыг нэмэгдүүлнэ.	Нийтийн биеийн тамирын боловсролыг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Эрүүл мэндийн яам Боловсролын яам
1.2.2.2	АХ-3.5.6	71701 Биеийн тамир, спорт	Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.	Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	

1.2.2.3	АХ-3.5.13	71701 Биеийн тамир, спорт	Олимп, Дэлхийн амжилтыг хадгалж, Азийн наадмын амжилтыг дээшлүүлнэ.	Спортын сургалт, дасгалжуулалтын уялдааг сайжруулах, тамирчдын залгамж халааг бэлтгэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
2			Үндэсний үр дүн (Бодлогын зорилго) 2: Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.		
2.1	АХ-3.3	Бүх салбар	Зохистой хөдөлмөр эрхэлж буй хүний тоог нэмэгдүүлнэ.	Зохистой ажлын байр бүтээгч ажил олгогчийг дэмжих	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.1	АХ-3.3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлыг бууруулна.	Идэвхтэй урьдчилан сэргийлэлтийг дэмжих	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.1.1	АХ-3.3	72103 Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулна.	Бүх талын мэдлэгийг нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.2	АХ-3.3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны чанарыг сайжруулна.	Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.2.1	АХ-3.3	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулна.	Нийгмийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.2.2	АХ-2.6	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Ур чадвар, мэргэжлийн сургалтыг дэмжих	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.2.3	АХ-2.6	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Залуучуудын идэвх, оролцоог нэмэгдүүлнэ.	Гарааны бизнес, энтрепренершипийг дэмжих	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.3	АХ-2.6	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлнэ.	Бүтээмж, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог сайжруулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.3.1	АХ-2.6.6	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Дундаж цалинг нэмэгдүүлнэ.	Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.3.2	АХ-2.6.10	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.	Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.1.4	АХ-3.3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн дэд бүтцийг хөгжүүлэх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
					Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2.1.4.1	АХ-3.3.3	72101 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангана.	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэх орчин, ур чадварыг сайжруулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.2	АХ-3.1	Нийгмийн хамгаалал	Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 50 хувьд хүргэнэ.	Тэтгэврийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг тогтмол өсгөх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.2.1	АХ-3.1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.2.1.1	АХ-3.1.2	71901 Нийгмийн даатгал	Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулна.	Цахим үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.2.1.2	АХ-3.1	71901 Нийгмийн даатгал	Иргэдийн хуримтлалын нэрийн дансны үлдэгдлийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Тэтгэврийн тогтолцоог гурван тулгуурт загвар болгон шинэчлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
2.2.1.3	АХ-3.1.7	71901 Нийгмийн даатгал	Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг нэмэгдүүлнэ.	Олон эх үүсвэрийг бий болгох	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ						
3	Үндэсний үр дүн (Бодлогын зорилго) 3: Үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлнэ.					
3.1	АХ-1.1	Соёл	Үндэсний соёлын дархлааг бэхжүүлнэ.	"Эх хэл, эх түүх, өв соёл"-ын бүтээлч хэрэглээг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
3.1.1	АХ-1.4	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Нийгмийн соён гэгээрлийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Ёс суртахуун, хариуцлагын соёлыг төлөвшүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Боловсролын яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батлан хамгаалах яам
3.1.1.1	АХ-1.2	71702 Соёл, урлаг	Соёлын боловсролын түвшнийг нэмэгдүүлнэ.	Үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
3.1.1.2	АХ-1.2	71702 Соёл, урлаг	Иргэдийн соёлын оролцооны түвшнийг нэмэгдүүлнэ.	Иргэд, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
3.1.2	АХ-1.2	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Нүүдлийн соёл иргэншлийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	Монгол үндэстний соёлын мөн чанарыг таниулан түгээх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
3.1.2.1	АХ-1.1.9	71706 Соёлын өв	Соёлын өвийн хамгаалалт, зохистой ашиглалтыг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн болон олон талт оролцоог нэмэгдүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

3.1.2.2	АХ-1.2.5	71706 Соёлын өв	Соёлын биет бус өв өвлөн уламжлагчийн тоог нэмэгдүүлнэ.	Соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, судалгаа шинжилгээнд инновац, өндөр технологи нэвтрүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
3.1.2.3	АХ-1.3	71706 Соёлын өв	Үндэсний хэл, бичгийн боловсролыг нэмэгдүүлнэ.	Хэрэглээг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Боловсролын яам Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
4			Үндэсний үр дүн (Бодлогын зорилго) 4: Нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.			
4.1	АХ-2.3	Нийгмийн хамгаалал	Хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлнэ.	Гэр бүлийн бодлогыг дэмжих	Эдийн засаг, хөгжлийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
4.1.1	АХ-2.2	Эрүүл мэндийн яам	Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.	Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Эрүүл мэндийн яам	
4.1.1.1	АХ-2.2.16	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулна.	Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсролын яам
4.1.1.2	АХ-2.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Жирэмсний хяналтад хамрагдахлыг нэмэгдүүлнэ.	Нөхөн үржихүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх	Эрүүл мэндийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
4.1.2	АХ-2.3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүлийн ээлтэй, тогтвортой байдлыг хангана.	Бүх нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	
4.1.2.1	АХ-1.2.1	72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал	Нийт хүн амын гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлнэ.	Зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Боловсролын яам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
4.1.2.2	АХ-2.1	71903 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	Ажил амьдралын тэнцвэрийг хангана.	Ажлын цагийг уян хатан зохицуулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	
4.1.3	АХ-3.1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулна.	Халамжийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	
4.1.3.1	АХ-3.1.12	71902 Нийгмийн халамж	Халамжийн үйлчилгээг оновчилно.	"Нийгмийн суурь үйлчилгээний загвар"-ыг нэвтрүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	
4.1.3.2	АХ-3.1.12	71902 Нийгмийн халамж	Ахмад настанд чиглэсэн цогц тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	

4.1.4	АХ-2.3	Эдийн засаг, хөгжлийн яам	Өрхийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.	Өмчийн эрхийн баталгааг сайжруулах	Эдийн засаг, хөгжлийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Монголбанк
4.1.4.1	АХ-2.3	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	Хүн ам зүйн ачааллыг бууруулна.	Иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэх	Эдийн засаг, хөгжлийн яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
4.1.5	АХ-4.6	Эдийн засаг, хөгжлийн яам	Үндэсний баялгийн сангийн иргэдэд хүрэх өгөөжийг нэмэгдүүлнэ.	Үндэсний баялгийн сангийн хараат бус, бие даасан, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх	Эдийн засаг, хөгжлийн яам	Сангийн яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
4.1.5.1	АХ-4.6.1	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	Хөгжлийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлнэ.	Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн ашиглалтын хяналтын механизм бий болгох	Эдийн засаг, хөгжлийн яам	Сангийн яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
4.2	АХ-5.5	Хууль, дотоод хэрэг	Хүний эрхийн баталгааг хангана.	Хүний эрхийн боловсролыг дэмжих	Хүний эрхийн Үндэсний Комисс	Боловсролын яам
4.2.1	АХ-5.5	Хүний эрхийн Үндэсний Комисс	Хүний эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.	Шүтэл үлээгчийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шалгалтыг эрчимжүүлэх	Хүний эрхийн Үндэсний Комисс	
4.2.1.1	АХ-5.5.1	70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих	Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлнэ.	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Хүний эрхийн Үндэсний Комисс	
4.2.1.2	АХ-5.5.1	70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих	Хүний эрх хамгаалагчид үзүүлэх дарамт, шахалтыг бууруулна.	Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг дэмжих	Хүний эрхийн Үндэсний Комисс	
4.2.2	АХ-5.1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлнэ.	Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	
4.2.2.1	АХ-5.5.7	72201 Жендэрийн тэгш байдлыг хангах	Улс төрийн болон бодлого боловсруулах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.	Жендэрийн квотыг хэрэгжүүлэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Төрийн албаны зөвлөл
4.2.2.2	АХ-2.2.14	72201 Жендэрийн тэгш байдлыг хангах	Эрэгтэйчүүдийн эрсдэлт зан үйлийг бууруулна.	Жендэрийн хэвшмэл буруу ойлголтыг арилгах	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	
4.2.3	АХ 2.3	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Залуучуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	Залуучуудын нийгмийн идэвх, санаачилга, хамтын ажиллагааг дэмжих	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	

4.2.3.1	АХ-2.3.3	72209 Залуучууд	Залуучуудын амьдрах ур чадварыг дээшлүүлнэ.	Эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах дадал, зан үйлийг хэвшүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсролын яам
4.2.3.2	АХ-2.3.3	72209 Залуучууд	Залуучуудын нийгмийн оролцоо, манлайллыг дэмжинэ.	Нийгмийн хөгжлийн төлөөх шийдвэр гаргах түвшинд оролцох боломжийг нэмэгдүүлэх	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Улсын их хурлын Тамгын газар
4.2.4	АХ-2.3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	Хүүхдийн эрхийг хамгаална.	Эцэг, эх, олон нийтийг хариуцлагажуулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хууль зүй, дотоод хэргийн яам Боловсролын яам
4.2.4.1	АХ-2.3.2	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулна.	Урьдчилан сэргийлэлт, илрүүлэлтийг сайжруулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хууль зүй, дотоод хэргийн яам Боловсролын яам
4.2.4.2	АХ-2.3.2	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	Хүүхэд хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.	Авьяасыг тасралтгүй хөгжүүлэх	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Боловсролын яам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
4.2.4.3	АХ-2.3.2	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулна.	Олон талт хяналтыг сайжруулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Боловсролын яам
4.2.4.4	АХ-2.3.2	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	Ахуйн ослоос урьдчилан сэргийлнэ.	Олон нийтэд зөв дадал суулгах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Боловсролын яам
4.2.5	АХ-7.3	Хууль зүй, дотоод хэргийн яам	Гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.	Иргэдийн ёс суртахуун, хүмүүжлийг сайжруулах	Хууль зүй, дотоод хэргийн яам	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
4.2.5.1	АХ-7.3.	70704 Цагдаа	Гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.	Дэвшилтэт технологи нэвтрүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн яам	
4.2.5.2	АХ-7.3.	70704 Цагдаа	Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Цагдаагийн ёс зүй, ур чадварыг нэмэгдүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн яам	
4.2.5.3	АХ-7.3.	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын бүсэд нэвтрүүлнэ.	Технологийн дэвшлийг нэвтрүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн яам	
4.2.5.4	АХ-7.4	70707 Шүүх шинжилгээ	Шүүх шинжилгээний дүгнэлттэй холбоотой гомдлыг бууруулна.	Шүүх шинжилгээний байгууллагын иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн яам	

4.2.6	AX-7.4	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгана.	Цагаатгагдсан иргэдийн холбогдох нөхөх олговрын мөнгийг төсөвт суулгах	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	
4.2.6.1	AX-7.4	72204 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах үйл ажиллагаа	Хэлмэгдүүлэлтийн үр дагаврыг арилгах чиглэлээр соён гэгээрүүлнэ.	Иргэдийн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	
4.3	AX-2.5	Хүнс	Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	Хүнс үйлдвэрлэл, үйлчилгээний бүх шатанд мөшгөх тогтолцоо, зохистой дадлыг нэвтрүүлэх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн) Эрүүл мэндийн яам Боловсролын яам Сангийн яам Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
4.3.1	AX-8.3.7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	Шинжлэх ухаан, технологи, инновац нэвтрүүлэлтийг дэмжих	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн)
4.3.1.1	AX-8.3.7	70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Олон улсын стандарт, шаардлага хангасан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Тээвэрлэлт, хадгалалтын сүлжээг өргөжүүлэх	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн)
4.3.1.2	AX-8.3.7	70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Малын дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, ашиглалтын түвшнийг сайжруулна.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санаачилгыг дэмжих	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн)
4.3.2	AX-2.5	Сангийн яам	Чанар, аюулгүйн баталгаатай импортын хүнсний бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлнэ.	Импортын хүнсний бүтээгдэхүүний баримт бичгийн бүрдэл, шошгололт, тээвэрлэлтийн хяналтыг сайжруулах	Сангийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
4.3.2.1	AX-2.5	70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	Импортын хүнсний шошгололтын шаардлага хангалтыг нэмэгдүүлнэ.	Хэрэглэгчийн хяналтыг дэмжих	Сангийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

4.3.2.2	АХ-2.5	70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	Импортын гол нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шаардлага хангалтыг нэмэгдүүлнэ.	Мэдээллийн ил тод байдал, цахим хяналтыг дэмжих	Сангийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
4.4	АХ-6.4	Барилга, хот байгуулалт	Орчны эрсдэлийн түвшнийг бууруулна.	Эрсдэлийн менежментийг сайжруулах	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)
4.4.1	АХ-4.2, АХ-6.3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Инженерийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	Нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Эрчим хүчний яам
4.4.1.1	АХ-4.2, АХ-6.4	71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага	Хүн амыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангана.	Иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
4.4.1.2	АХ-4.2, АХ-6.4	71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага	Хүн амыг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангана.	Хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
